



ЭМНЭЛЭГ, АМБУЛАТОРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

ЗОРИЛГО: Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлдэг төсөл хөтөлбөрүүдийн үндсэн долоон чиглэлийн нэг нь эрүүл мэндийн салбар юм. Үйл ажиллагаа эрхэлж буй орон нутгийн эрүүл мэндийн салбарыг чадавхжуулж, хөгжүүлэх зорилготой.

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД: 2006 оноос нийгмийн хөрөнгө оруулалтын хүрээнд нийслэл, аймаг, сумын эрүүл мэндийн салбарт тодорхой төсөл хөтөлбөрүүдийг компаниас санхүүжүүлэн хэрэгжүүлсэн. Тухайлбал: Монгол улсын "Аксион Монголи" ТББ – тай хамтран Улаанбаатар хотын Шастины нэрэмжит 3-р эмнэлэг, "Өргөө" амаржих газар, Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэгт дурангийн хагалгааны иж бүрэн аппарат хүлээлгэн өгч, эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслын чиглэлээр эмч мэргэжилтнүүдийг жил бүр Франц улсын Лион хотын эмнэлэгт богино хугацааны дадлага хийхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Мөн 2017, 2018 онуудад Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэг, Улаанбадрах сум, Сайншанд сумын Зүүнбаян баг, Айраг сумын эмнэлгүүдэд түргэн тусламжийн үйлчилгээний машин, дугуйт ор, матрасны хамт, шүүгээ, хүчилтөрөгч өтгөрүүлэгч, ханын агааржуулагч, тусгай хэрэгцээний хөргүүр зэрэг нэн шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг нийлүүлсэн.

Компаниас эрүүл мэндийн салбарт нийт 900 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээд байна.



Төслийн явцын тухай мэдээллийг бидний Фэйсбүүк хуудаснаас авна уу.
<https://www.facebook.com/badrakhenergy>